



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/411

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.
2. Магадлан итгэмжлэлийн хугацаа тасарч сунгагдаж буй эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэл эхлэх хугацааг 2022 оны 8 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн тооцсугай.
3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 15 дугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141221941

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 08
дугаар сарын 16 ны өдрийн АНН
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн Дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	"Интерферон альфа" ХХК-ийн эмнэлэг	268/2022	1 жил	2022.08.11	2023.08.11
2.	"Суперпроб" ХХК-ийн "Мөнгөн гүүр" эмнэлэг	269/2022	4 жил	2022.08.17	2026.08.17
3.	Булган аймаг, Хангал сумын эрүүл мэндийн төв	270/2022	2 жил	2022.08.11	2024.08.11
4.	Говь-Алтай аймаг, Гуулин тосгоны эрүүл мэндийн төв	271/2022	3 жил	2022.08.27	2025.08.27
5.	Говь-Алтай аймаг, Хөхморьт сумын эрүүл мэндийн төв,	272/2022	2 жил	2022.08.27	2024.08.27
6.	Говь-Алтай аймаг, "Дүгнэн" ХХК-ийн "Дүгнэн" сувилал	273/2022	1 жил	2022.08.11	2023.08.11
7.	Орхон аймаг, "МНЦО" ХХК-ийн "Мишээл" эмнэлэг	274/2022	2 жил	2022.08.11	2024.08.11
8.	Орхон аймаг, "Шижирцацрагт" ХХК-ийн "Шинэ Эрин Мед" клиник	275/2022	2 жил	2022.08.11	2024.08.11
9.	Орхон аймаг, Оюу Орхон ХХК-ийн "Оюу" клиник	276/2022	1 жил	2022.08.11	2023.08.11
10.	Орхон аймаг, "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн Эрдэнэт сувиллын цогцолбор	277/2022	4 жил	2022.08.27	2026.08.27
11.	Хэнтий аймаг, Аймгийн нэгдсэн эмнэлэг	278/2022	4 жил	2022.08.13	2026.08.13
12.	Хэнтий аймаг, Баян-Овоо сумын эрүүл мэндийн төв	279/2022	4 жил	2022.08.13	2026.08.13
13.	Хэнтий аймаг, Баянмөнх сумын эрүүл мэндийн төв	280/2022	2 жил	2022.09.07	2024.09.07
14.	Хэнтий аймаг, Батширээт сумын эрүүл мэндийн төв	281/2022	4 жил	2022.08.13	2026.08.13
15.	Хэнтий аймаг, Бэрх эрүүл мэндийн төв	282/2022	3 жил	2022.08.13	2025.08.13
16.	Хэнтий аймаг, Жаргалтхаан сумын эрүүл мэндийн төв	283/2022	3 жил	2022.08.13	2025.08.13
17.	Хэнтий аймаг, Норовлин сумын эрүүл мэндийн төв	284/2022	3 жил	2022.08.13	2025.08.13
18.	Хэнтий аймаг, Цэнхэрмандал сумын эрүүл мэндийн төв	285/2022	2 жил	2022.08.13	2024.08.13
19.	Хэнтий аймаг, Хэрлэнбаян-Улаан тосгоны эрүүл мэндийн төв	286/2022	2 жил	2022.08.13	2024.08.13